



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОМА-2023/110/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Өмнөговь аймаг 2023 он	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас:99014247 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Болормаа Утас:80077408 Цахим хаяг: bolormaaja@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК Утас:99099119 Цахим хаяг:gerelthuhaudit@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын өрхөн 304, 1001, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 49083
Утас: (376) 7053 3539, Цэвэр хуудас: 7053 3539
Цахим хуудас: omnogov@audit.gov.mn

2023.02.09 № 22

төрийн _____-ын № _____

**ДАЛАНЗАДГАД СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 1-Р СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Д.ЭНХЖАРГАЛ ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Даланзадгад сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгөтөмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Даланзадгад сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв тогилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдах байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөр 6 дугаар ангийн суралчдыг үдийн хоол хөтөлбөрт хамруулсан байна.

Аудитын гол асуудал

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийсэн урлагийн заалны зураг төсвийг хүлээн авснаар бараа материал дансны үлдэгдэл 24.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтад "Хувьсах зөрдлын дундаж нормативаар санхүүжүүлэх аргачлал" батлагдаж боловсролын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд санхүүжүүлдэг болсон байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж тогилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	329.5	486.1
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,552.9	5,241.6
Нийт хөрөнгийн дүн	3,882.4	5,727.7
Нийт өр төлбөрийн дүн	-	-
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,882.4	5,727.7
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,882.4	5,727.7
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	2,738.3	5,616.7
Үйл ажиллагааны зардлын дүн	2,876.3	3,770.2
Үйл ажиллагааны үр дүн	(137.9)	1,846.5
Үйл ажиллагааны бус үр дүн	61.3	1.1
Үйл ажиллагааны нийт үр дүн	(199.2)	1,845.3
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Засгийн газрын оруулсан капитал	2,602.8	2,602.8
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,825.2	1,735.4
Хуримтлагдсан үр дүн	(346.4)	1,389.5
Эцсийн үлдэгдэл	4,081.7	5,727.7
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,628.4	3,649.4
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	2,597.7	3,512.3
Үйл ажиллагааны ЦМГ	30.8	137.0
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(30.8)	(85.6)
Санхүүгийн үйл ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	51.4
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	51.4
Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	3,509.8	3,421.5
Урсгал зардал	3,509.8	3,362.5
Хөрөнгийн зардал	-	58.9
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	3,509.4	3,472.9
Улсын төсвөөс санхүүжих	3,151.4	3,151.4
Орон нутгийн төсвөөс санхүүжих	358.0	314.3
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		51.4

Гурав. Аудитын илрүүлэлт: Аудитаар нийт 43.9 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 42.2 сая төгрөгийн 6 алдааг залрууллаа.

Аудитаар Саммит компьютер ХХК-иад 33.4 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн үнэ шилжүүлээд захиалсан тоног төхөөрөмж нь ирээгүй хөрөнгийг данс бүртгэлд тусгасан, ФючерсСкүүл Монголий ХХК-с худалдан авсан Шалгалтын хариу засах 7.0 сая төгрөгийн үнэ бүхий программ хангамжийг шууд зардалд бүртгэсэн, Нийгмийн даатгалын илүү төлөлт 0.4 сая төгрөгийг авлага дансанд бүртгээгүй, тоглоомын талбай нэршилтэй хөрөнгийн ашиглах жилийг 60 жил гэж буруу бүртгэсэн, бараа материалын шинж чанартай 0.4 сая төгрөгийн үнэ бүхий 1 ширхэг чихэвч гэсэн хөрөнгийн зүйлийг үндсэн хөрөнгө дансанд буруу бүртгэсэн, бусад хангамжийн материалд бүртгэлтэй 0.9 сая төгрөгийн үнэ бүхий уртасгагч, ажлын хувцас сөрөг утгатай тайлагнагдсан алдааг залрууллаа.

Аудитаар нийт 20.7 сая төгрөгийн зөрчил² илрүүлж тус зөрчилд 1 албан шаардлага, 1 заалт бүхий зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага

5.2.1 Зардлын бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус сургуулийн интернэтийн төлбөрийг Боловсролын мэдээллийн технологийн төв УТҮГ-аас төлсөн байхад 2022 онд интернэтийн төлбөрт 1.7 сая төгрөг төлж төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах” гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Боловсролын мэдээллийн технологийн төв УТҮГ-тай гэрээ байгуулан интернэтийн үйлчилгээ үзүүлж байгаа аж ахуйн нэгжтэй холбогдон сургуулийн интернэтийн тоног төхөөрөмжийг хүлээн авч үйл ажиллагаандаа тус интернэтийг хэрэглэн төсвийн хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлэн ажиллаж төсвөөс мөнгөн хөрөнгө давхардуулан гаргаж байгааг таслан зогсоох.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: 2022 оны 8 сард Бат арвай трейд ХХК-иас 19.0 сая төгрөгийн компьютер худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 “*Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно*” гэсэн заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасны дагуу цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад газраас худалдан авдаг байдлыг зогсоож хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл												
/мянган төгрөгөөр/												
Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигловсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Авлагыг данс бүртгэлд тусгаагүй	1	33,382.0			1.0	5,527.2	1.0	5,527.2				
Авлагыг данс бүртгэлд тусгаагүй	1	440.9			1.0	59,883.4	1.0	59,883.4				
хөрөнгө данс бүртгэлд тусгаагүй	1	7,000.0										
Хөрөнгө данс бүртгэлд ашиглах жил буруу тооцсон	1	-										
Бараа материалыг буруу бүртгэсэн	1	385.0										
Бараа материалыг буруу бүртгэсэн	1	946.0										
Дүн	2	33,822.9			2.0	65,410.6	2.0	65,410.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл												
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Интернетийн төлбөрийг давхардуулан төлсөн	1	1,730.3			1	1,730.3						
Дүн	1	1,730.3			1	1,730.3						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал								
/мянган төгрөгөөр/								
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Алдаа илэрээгүй								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Төрийн хэмнэлтийн хууль	1	19000.0					1	19000.0
Дүн	1	19000.0					1	19000.0